

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

О.Бат-Эрдэнэ

Хураангуй: Энэхүү өгүүлэлд хөрөнгө болон хөрөнгө оруулалтын талаар дэлхийн болон Монгол Улсын эрдэмтэн судлаачдын дэвшүүлсэн онолын үзэл баримтлал, чиглэлүүд, тэдгээрийн зүгээс хөрөнгө оруулалт, хуримтлалын улс орны эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөлөл, тэдгээрийн хоорондын хамааралыг харьцуулсан судлаж, Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд хөрөнгө оруулалт, хуримтлалын үзүүлж байгаа бодитой нөлөөг эдийн засаг, эконометриксийн загвараар тооцож, улс орны эдийн засгийн өсөлтөд эдийн засагт үзүүлэх хуримтлал, цэвэр экспортын хэмжээ хангалтгүй, бага үйлдвэрлэж их хэмжээгээр хэрэглэж, эдийн засгийн өсөлтийг урамшуулах хэмжээний хуримтлал бий болж чадахгүй байна гэж дүгнэсэн байна. Ийм байдлыг засахын тулд шинжлэх ухааны судалгаанд тулгуурласан урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын төлөвлөлтийг хийх, төрийн бодлогын залгамж чанар хангах, аж үйлдвэр болон дэд бүтэцийн сүлжээг байгуулахад гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг чиглүүлэх, гадаад зах зээлийн өндөр хамааралыг бууруулах зорилгоор уул уурхайн болон мал аж ахуйн түүхий эдийг бүрэн боловсруулж импортыг орлох бүтээдэгдэхүүний хэмжээг нэмэгдүүлж байж хуримтлал, хөрөнгө оруулалтын эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэх үүргийг нэмэгдүүлж чадна гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Түлхүүр үгс: Монгол Улс, хөрөнгө, хөрөнгө оруулалт, хуримтлал, эдийн засгийн өсөлт, ДНБ, уул уурхай, мал аж ахуй, санхүү, эдийн засгийн хямрал, үнэ тариф гэх мэт.

* О.Бат-Эрдэнэ УИХ-ын тамгын газар гишүүний зөвлөх Емайл хаяг: Ochirbaterdene@yahoo.com.

Капитал гэдэг үг нь “capitalis” (гол, зонхилох, үндсэн) гэсэн лагин үгнээс гаралтай ашиг олох зорилгоор ашиглагдах хөрөнгө гэж тайлбарлаж байна. Капитал гэсэн үгийг бид Монгол хэлэнд “хөрөнгө” гэж орчуулан хэрэглэж хэвшсэн байдаг.

Шотландын гүн ухаантан, эдийн засагч, эдийн засгийн сонгодог онолыг үндэслэгч Адам Смит анх “Үндэстний баялаг, түүний шалтгаан” (1776) гэсэн номондоо “Аливаа орны эдийн засгийн гол зорилго нь, түүний баялагийг нэмэгдүүлж, хүчирхэг болгох явдал гэж үзээд жирийн иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэхэд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хөдөлмөрийг хөнгөвчилсөн машин техникийг нэвтрүүлэх нь зайлшгүй чухал” гэж бичжээ¹.

Түүнчлэн А. Смит ашиг, орлого олдог онцлогоос нь хамааруулан хөрөнгийг үйлдвэрлэлийн үйл явцад урт хугацаанд ашиглагдаж, ашиглалтын турш өөрийн өртгийг үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний үнэд хэсэгчлэн шингээж байдаг хөрөнгийг үндсэн хөрөнгө, зөвхөн нэг үйлдвэрлэлийн мөчлөгт ашиглагдаж, өөрийн өртгийг бүтээгдэхүүнд нэг мөр шингээдэг хөрөнгийг эргэлтийн хөрөнгө гэж хоёр хэсэгт ангилсан байна.

Өөрөөр хэлбэл хүн өөрийн хүч хөдөлмөр чармайлтынхаа үр дүнд тодорхой хэмжээний хуримтлал, нөөцтэй болж, дараагийн ээлжийн эдийн засгийн үйл ажиллагааг явуулахдаа ашгийн хуримтлалаа дахин хөрөнгө оруулалт болгох замаар шинээр нэмэлт орлого олох боломж бүрдүүлдэгт хөрөнгийн ач холбогдол оршиж байна.

Тэгвэл германы гүн ухаантан, марксист онолыг үндэслэгч Карл Маркс өөрийн “Капитал” хэмээх бүтээлдээ “капитал бий болох урьдчилсан нөхцөл бол таваарын үйлдвэрлэл ба таваарын гүйлгээ, худалдаа юм” гэж үзжээ².

Төрийн зохицуулалттай эдийн засгийн онолыг үндэслэгч Жон Кейнс: “хөдөлмөр эрхлэлт, хүү зээл, хөрөнгө мөнгөний ерөнхий онол” зохиолынхоо “орлого, хуримтлал, хөрөнгө оруулалтыг тодорхойлж, үндэсний нийт бүтээгдэхүүн нь нийгмийн нийт хэрэглээ ба хөрөнгө

1 Адам Смит “Үндэстнүүдийн баялаг буюу түүний шалтгаан, гарал үүслийн тухай судалгаа” 2 дугаар дэвтэр 5 дугаар бүлэг 290 дахь тал Ч.Энхээгийн орчуулга Улаанбаатар хот 2011 он.

2 Карл Маркс “Капитал” том первый стр 210-222 Москва 1988 г.

оруулалтаас бүрэлдэнэ³ гэсэн томъёоллыг гаргасан байна.

Ж.Кейнс хөрөнгө оруулалтын үр ашгийн тухай асуудлыг тодорхойлохдоо “эдийн засгийн хямралыг даван гарахын тулд төсвийн алдагдал хүлээгээд ч болов улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг нэмэгдүүлэх замаар бүрэлдэн бий болсон эдийн засгаа дампуурлаас аврахад засгийн газар гол үүрэгтэй” гэсэн санаагаа илэрхийлсэн байдаг.

Энд дүгнэлт хийхэд Ж.Кейнс нь эдийн засагт төрийн оролцоог аль болох бага байлгахын чухалыг тунхагладаг чөлөөт зах зээлийн сонгодог онолын эсрэг эдийн засагт оролцох төрийн оролцоо, зохицуулалтын ач холбогдлыг дэмжсэнээрээ төрийн зохицуулалттай эдийн засгийн онол гэсэн чиглэлийг бий болгосон билээ.

Хөрөнгө оруулалт гэж аливаа бизнесийн (дэд бүтэц, хөдөө аж ахуй, аж үйлдвэр) үйл ажиллагаанд урт хугацаанд хөрөнгө оруулж ашиг (ногдол ашиг) олох зорилготой шийдэл, түүний хэрэгжилтийг судалдаг шинжлэх ухаан юм⁴.

Иймд ашиг олох зорилгоор үнэт цаас, эд хөрөнгө худалдан авах, эсхүл ямар нэг бараа үйлдвэрийн тоног төхөөрөмж, байшин барилга худалдаж авах зэрэг нь хөрөнгө оруулалт юм. Өргөн утгаараа макро түвшинд хөрөнгө оруулалт нь улс орны эдийн засгийн өсөлт, хөгжлийг санхүүжүүлэх механизм гэж үзэж болно. Энэ утгаараа улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардал нь аливаа улсын бүтээн байгуулалтын ажлын санхүүжилтийн эх үүсвэр болдог байна.

Хөрөнгө оруулалтын агуулгын талаар доктор (Sc.D), профессор Ц.Аюурзана “хөрөнгө оруулалт бол хөгжлийн түлхүүр юм. Үйлдвэрлэл үйлчилгээний үр ашгийг дээшлүүлж, хүнд хүрэх өгөөжийг нэмэгдүүлэх замаар ашиг орлогийг өсгөх зорилгоор урьдчилан оруулж байгаа хөрөнгө юм. Энэ нь зөвхөн мөнгөн хөрөнгө төдийгүй хувь оролцоо, хувьцаа ба бусад үнэт цаас, шинэ технологи, машин тоног төхөөрөмж, лиценз, зээл бусад эд хөрөнгө, түүнчлэн эд хөрөнгө эзэмших эрх, оюуны үнэт зүйл байж болно. Мөн хөрөнгө оруулалт бол эцсийн

3 Жон Мэйнард Кэйнс “ Хөдөлмөр эрхлэлт, хүү зээл, хөрөнгө мөнгөний ерөнхий онол” 88-89-р тал Улаанбаатар 2014 он.

4 Райзберг Б. А., Лозовский Л. Ш., Стародубцева Е. Б. Современный экономический словарь. :М. Инфра-М, 2006.

зорилго биш бөгөөд харин зорилгод хүрэх хэрэгсэл, хөгжлийн оньсон түлхүүр юм”⁵.

Хөрөнгө оруулалтын ач холбогдолын талаар доктор (Sc.D), профессор Д.Цэрэнпил: “Хөрөнгө оруулалтын динамик үзүүлэлт аль ч орны эдийн засаг, нийгмийн чадавхийн хөгжлийг тодорхойлох макро эдийн засгийн чухал хэмжүүр юм. Шилжилтийн эдийн засагтай тэгээд хямрал бэрхшээл тулгарсан улс орны хувьд эдийн засаг нийгмийн байдлыг тогтворжуулж цаашдын нөхцөлийг хангах зайлшгүй нөхцөл бол үйлдвэрлэлийн хүчин чадлыг сэргээх, шинэчлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх явдал юм”⁶ гэжээ.

Доктор Д.Моломжамц бүтээлдээ “хөрөнгө оруулалт бол эцсийн үр дүнд чиглэсэн урьдчилгаа капиталыг оруулж, төлөвлөсөн үр дүнг олохтой холбоотой, макро ба микро түвшинг хамарсан нийлмэл харилцаа, уг харилцааг оновчтой болгох тодорхой арга хэрэгсэл, зохион байгуулалтыг багтаасан зорилго чиглэл бүхий үйл ажиллагаа юм”. Өөрөөр хэлбэл, үндсэн капиталыг бий болгох, шинэчлэх, үйлдвэрийн газрын техникийн шинэчлэлт тоноглолт, боловсронгуй болгох, сайжруулах зорилгоор шинээр байгуулах, түүнчилэн хувьцаа, өрийн бичиг болон бусад үнэт цаас ба активуудыг олж авах зорилгоор зарцуулж байгаа төр засаг, аж ахуйн нэгж болон бусад этгээдийн мөнгөн хөрөнгө зэргийг хамааруулан ойлгож болно.⁷

“Хөрөнгө оруулалт” ба “хөрөнгө оруулах” гэсэн ойлголтуудыг тодорхойлох хандлагуудыг харьцангуйгаар онолын ба нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн гэж ангилдаг тухай Э.Дж.Долан ба Д.Е.Линдсей нар зах зээлийн эдийн засгийн талаар бичсэн бүтээлдээ тэмдэглээд макро түвшин дэх хөрөнгө оруулалтыг “эдийн засгийн системд үйлчилж байгаа капиталын хэмжээг нэмэгдүүлэх, өөрөөр хэлбэл хүмүүсийн хэрэгжүүлж байгаа үйлдвэрлэлийн нөөцийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх” гэж тодорхойлсон байна.

Зах зээлийн хууль гэж нэрлэгдэх болсон макро эдийн засгийн эрэлт, нийлүүлэлтийн сонгодог загварыг боловсруулсан францын эдийн засагч Жан Батист Сэйгийн бүтээлд “хөрөнгө оруулалт нь эдийн

5 Ц.Аюурзана. “Санхүүгийн менежмент” УБ 2007 127-р тал

6 Д.Цэрэнпил “Санхүүгийн шинэчлэл: Судалгаа, тулгамдсан асуудал” УБ 2006 245-р тал

7 Д.Моломжамц. “Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн шинэчлэлт” нэг сэдэвт бүтээл

засгийн хөгжлийн суурь мөн гэж үзсэн байна. Дээрхи эдийн засгийн онолуудын томоохон төлөөлөгчдийн бүтээл, дэвшүүлсэн санаа, томьёололыг харьцуулан хөрөнгө болон оруулалтын талаарх нийтлэг зүй тогтолыг нэгтгэн үзвэл:

1. Нийгмийн оршин тогтнох үндэс болсон материал баялагийн нөөц нь үйлдвэрлэн бүтээх үйл ажиллагааны дүнд бий болж, аривжиж байдаг;

2. Хүний нийгмийн амьдралын шууд хэрэгцээг хангадаг үйлдвэрлэл, үйлчилгээний эцсийн бүтээгдэхүүн нь хөрөнгө хэмээх хүчит хэрэгслийн тусламжтайгаар бий болдог;

3. Хүн өдөр тутмын хэрэглээндээ зориулагдсан нөөцөөсөө илүүдэл хэсгийг хуримтлал болгон ашиг олох хэрэгсэл болгон хувиргах боломжтой тул “хүний хөдөлмөрөөр бүтсэн материаллаг зүйл нь хөрөнгөд хамаарна”⁸ гэж А.Маршал тодорхойлсон байна.

Орчин үеийн нобелийн шагналтнуудын эдийн засгийн өсөлтийг тодорхойлохдоо үйлдвэрлэлийн гол хүчин зүйл болсон хөрөнгө буюу хуримтлалаас хамаарсан загвар функцуудыг бүтээсэн байдаг. Тухайлбал, английн эдийн засагч Р.Харрода, америкийн эдийн засагч Е. Домара нар 1940-өөд оны үед эдийн засгийн өсөлтийг хөрөнгөөс хамааруулж тооцсон загварыг зохиосон.

Р.Харрода, Е.Домара нар өөрсдийн загвар дээр тулгуурлан эдийн засгийн өсөлтийн хамаарлыг тодорхойлохдоо хэдий чинээ их хуримтлал бий болно тэр хэмжээгээр хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж, эдийн засгийн өсөлт хурдасна, хэдий чинээ хөрөнгө агууламж их байна төдий чинээ эдийн засгийн өсөлтийн хурд саарна гэж тайлбарласан. Энэ нь хуримтлал, хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлт шууд хамааралтай харин үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд шингэж байгаа хөрөнгийн зардал их байх нь эдийн засгийн өсөлтөд урвуу хамааралтайг нотолж байна.

Тэгвэл АНУ-ын эрдэмтэн, эдийн засагч Василий Леонтьев “Орцгарцын” гэж алдаршсан эдийн засгийн шинжилгээндээ “хэрэглээ, хөрөнгө оруулалт, экспортын эцсийн төлөвлөсөн буюу шаардагдах өсөлтийг хангахад эдийн засгийн ямар салбаруудын үйлдвэрлэлийг

8 Альфред Маршалл “ Эдийн засгийн ухааны зарчмууд” 109-113-р тал Чойбалсан хот 1997 он

хэдий хэмжээгээр өсгөх ёстойг тогтоох явдал юм” гэж үзсэн байдаг.

Ийнхүү бидний ойлгож байгаагаар хөрөнгө оруулалт гэж ашиг орлого олох, эсвэл, өөр тааламжтай үр дүнд хүрэх, хөрөнгө эзэмшигчдийн хөрөнгийн үнэ цэнийг өсгөх зорилгоор компанид оруулж байгаа мөнгөн хөрөнгө, үнэт цаас, бусад хөрөнгө, түүний дотроос мөнгөн үнэлгээгээр илэрхийлэгдэх хөрөнгийг өмчлөх эрх гэх зэрэг үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг нийтэд нь хамааруулсан өргөн ойлголт болох нь харагдаж байна. Эдгээр онолын үндэслэлүүдийг ашиглаж Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд хуримтлалын (хөрөнгө оруулалт) үзүүлж байгаа нөлөөллийн тооцож үзье.

Зураг 1-ээс харна уу.



Монгол Улс зах зээлийн харилцаанд шилжиж эхэлсэн эхний 4 жилийн турш эдийн засгийн өсөлт хасах үзүүлэлттэй болж, 1994 оноос эхлэн эдийн засгийн өсөлт ажиглагдаж байсан боловч чанарын өөрчлөлт төдийлөн гарахгүй байж байгаад 2003 оноос эхлэн 2018 оныг хүртэл өндөр өсөлттэй байв. Гэвч 2009 оны дэлхий санхүүгийн хямралын улмаас -1,3 хувь хүртэл унасны дараа дэлхийн зах зээл дээр манай улсын уул уурхайн экспортын түүхий эдийн үнэ огцом өссөж гадаад нөхцөл байдал таатай болсонтой холбоотой маш богино хугацаанд эдийн засаг сэргэж манай улсын эдийг засаг руу маш их

хэмжээний гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламж орж ирснээс дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэж ашигт малтмалын үнийн өсөлтийн албан татварыг алт, зэсийн баяжмалд ноогдуулснаар улсын төсвийн орлогыг нэмэгдүүлж, төсвийн хөрөнгө оруулалтыг ихээхэн тэлсэн байдаг. Ингэснээр манай улсын эдийн засаг 2011 онд түүхэндээ байхгүй 17,3 хувийн өндөр өсөлттэй гарсан байдаг. Харамсалтай нь дэлхийн зах зээл дээр таатай нөхцөл байдал удаан үргэлжлээгүй учир 2011 оноос хойш эдийн засгийн нөхцөл байдал муудахад эдийн засаг дах хуримтлалын хувийн жин тасаралтгүй буурч 2016 онд 1 хувь болсон байна. Харин 2017 оноос эдийн засаг сэргэх хандлага илэрч байна.

Джон Кейнс: “шилжилтийн эдийн засагт хуримтлалын хэмжээг тодорхойлоход орлого, инфляцийн хүлээлт чухал үүрэг гүйцэтгэдэг. Өрхийн хуримтлалыг үүсгэх гол шалтгаан бол макро эдийн засгийн таатай нөхцөл, иргэдийн хуримтлалыг хамгаалах төрийн баталгаа гэж үзсэн”⁹.

Хуримтлалын өсөлт нь үндэсний нийт орлогын өсөлт, үйлдвэрлэлийн зардал, түүний хүчин чадал, хангамж, үнэ тарифийн түвшин болон татварын бодлогын зэргээс хамаардаг. Өөрөөр хэлбэл хэдийн чинээ өндөр үндэсний орлого, бага татвар байна төдий чинээ хуримтлал өндөр байдаг. Тэгвэл хуримтлалын өсөлтөд зээлийн хүү сөрөг нөлөө үзүүлдэг байна. Өөрөөр хэлбэл хэдий чинээ зээлийн хүү өндөр байна хуримтлалын норм болон хэмжээ төдийн чинээ бага байдаг байна. Түүнчлэн санхүүгийн зуучлалын хөгжлийн түвшин, санхүүгийн хэрэгсэлүүдийн хангалтын түвшингээр тодорхойлогдог.

Эдийн засаг дах хуримтлал нь ажил эрхлэлт, аж үйлдвэрийн салбарын хөгжүүлэх, хүн амын орлогын зөрүү болон албан бус эдийн засгийн хэмжээг багасгах зэрэг асуудлыг шийдэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Макро эдийн засагт хуримтлал бол төрийн зүгээс ирээдүйд тодорхой зорилгод хүрэхэд хуваарилсан санхүүгийн нөөцийн хэсэг бөгөөд цаашдаа улс орны хөгжилд хөрөнгө оруулалт болж, үндэсний нийт орлогод багтаан тооцож байна. Хуримтлалын норм нь 10-40 хувьтай тэнцүү байвал зохимжтой гэж үздэг.

9 <http://www.grandars.ru/student/ekonomicheskaya-teoriya/keyns.html>

Хөгжингүй орнуудын ДНБ-д хуримтлалын эзлэх хувийн жин 22-24 хувь байдаг бол хөгжиж байгаа орнуудад 26 хувь байна¹⁰. Монгол Улсын ДНБ-д хуримтлалын эзлэх хувийн жинг хүснэгт 1-ээс харна уу.

Хүснэгт 1. ДНБ-ий бүтэц, ашиглалтын аргаар (оны үнээр)

Он	ДНБ-ний хэмжээ	Эцсийн хэрэглээ	Нийт хуримтлал	Цэвэр экспорт
2004	100	77,2	33,1	-10,3
2005	100	67,3	36,6	-3,9
2006	100	59,6	34,8	5,6
2007	100	60,6	38,0	1,1
2008	100	92,1	43,0	-10,3
2009	100	94,8	34,5	-5,1
2010	100	67,9	42,1	-7,4
2011	100	63,7	58,2	-17,3
2012	100	66,5	55,9	-16,5
2013	100	69,3	53,3	-14,8
2014	100	69,6	35,2	-0,3
2015	100	72,6	26,4	0,5
2016	100	67,7	29,5	1,9

Тайлбар: Үндэсний статистикийн хорооны 2004-2016 оны жил тутамын статистикийн эмхэтгэлийн үзүүлэлтүүдэд үндэслэн тооцов.

Хүснэгт 1-ээс харахад Монгол Улсын эдийн засагт хуримтлалын эзлэх хувийн жин тийм ч бага биш байна. Гэвч үндэсний аж үйлдвэрийн сул хөгжил, өндөр инфляц, тээврийн өндөр зардал, эдийн засагт импортын эзлэх хувийн жин өндөр, гадаад зах зээлийн өндөр хамаарал зэрэг шалтгаалан хуримтлалын эдийн засгийн өсөлтөд доривтой эерэг нөлөө үзүүлж чадахгүй байна. Энэ байдалд зөвхөн гадаад, дотоод эдийн засгийн хүчин зүйл нөлөөлснөөс гадна дотоод улс төрийн болон засаглалын хүчин зүйл нөлөөлсөн гэж үзэх үндэстэй юм. Учир нь эдийн засгийн өндөр өсөлтөөс орж ирсэн төлөвлөгдөөгүй их орлогыг тухайн үеийн засгийн газар эдийн засагт зохистой байршуулж хуваарилж

¹⁰ <https://utmagazine.ru/posts/12838-norma-nakopleniya>

Монгол Улсын эдийн засагт хөрөнгө оруулалтын үзүүлэх нөлөөлөл

чадалгүй төсвийн зардлыг маш их хэмжээгээр хэтрүүлж, төсвийн хөрөнгө оруулалтын зарцуулалтыг үр ашиггүй зардалд зарцуулсаны улмаас эдийн засгийн тасралтгүй нөхөн үйлдвэрлэлийг хангах үүрэг бүхий аж үйлдвэрийн салбарын хөгжилд доривтой дэмжлэг үзүүлэх бодлогын залгамж шинж чанар алдагдаж, хямралын үе дэх эдийн засгийн дархлаа байхгүй болж эмзэг байдал улам нэмэгдэж гадаад дотоод өрийн хэмжээ нэмэгдэх үндсэн нөхцөл болж, гадаад хөрөнгө оруулалт 2014 онд зогссон үзүүлэлт гарч байлаа. ДНБ-д хуримтлал буюу хөрөнгө оруулалтын нөлөөллийг хүснэгт 2-оос харна уу.

Хүснэгт 2. ДНБ-д хуримтлал буюу хөрөнгө оруулалтын нөлөөллийг ашиглалтын аргаар тооцсон байдал (Оны үнээр)

	ДНБ-ний хэмжээ	Эцсийн хэрэглээ	Нийт хуримтлал	Цэвэр экспорт
	у	х1	х2	х3
2007	5042488,7	5042488,7	1918477,2	57132,1
2008	6639320,4	6639320,4	2856008,6	-680845,2
2009	6568403,4	6568403,4	2265264,3	-337768,6
2010	9756588,4	9756588,4	4106250,9	-718994,6
2011	13173763,4	13173763,4	7660639,0	-2279019,5
2012	16688419,6	16688420,0	9328596,0	-2755327,8
2013	19174242,7	19174243,0	10215213,7	-2831612,2
2014	22227054,3	22227054,0	7818432,4	-58973,5
2015	23150385,6	23150386,0	6114629,4	117966,0
2016	23886409,5	24179998,0	7053085,1	441944,1

SUMMARY OUTPUT

Regression Statistics	
Multiple R	0,9999
R Square	0,9998
Adjusted R Square	0,9998
Standard Error	90750,7
Observations	10

ANOVA					
	df	SS	MS	F	SignificanceF
Regression	3	4,8746	1,6248	19729,6	2,28E-12
Residual	6	4,9414	8,2357		
Total	9	4,8751			

	Coefficients	Standard Error	t Stat	P-value	Lower 95%	Upper 95%	Lower 95,0%	Upper 95,0%
Intercept	28029,09	70206,2	0,3992	0,7035	-14376	199817,7	-14376	199817,7
X Variable 1	1,00289	0,0210	47,662	5,7180	0,9514	1,0543	0,9514	1,0543
X Variable 2	-0,0273	0,0663	-0,412	0,6943	-0,1896	0,1349	-0,1896	0,1349
X Variable 3	-0,0689	0,1023	-0,674	0,5252	-0,3193	0,1814	-0,3193	0,1814

Тайлбар: Үндэсний статистикийн хорооны 2007-2016 оны жил тутамын статистикийн эмхэтгэлийн үзүүлэлтүүдэд үндэслэн тооцов.

$GDP(Y) = 1,0028$ Эцсийн хэрэглээ ($X1$) - $0,0273$ Нийт хуримтлал ($X2$) - $0,0689$ Цэвэр экспорт ($X3$)

Тэгшитгэлээс харахад Монгол Улсын эдийн засгийн өсөлтэй адилхан динамикаар эцсийн хэрэглээ өсөж байна. Эдийн засаг 1 хувиар өсөхөд эцсийн хэрэглээ 1,0028 хувиар өсөж, нийт хуримтлал 0,027 хувиар буурсан, цэвэр экспорт 0,068 хувиар буурсан $R\ Square = 0,9998$ гарсан нь бидний хийсэн тооцоо үндэслэлтэй гэж үзэхэд хүргэж байна. Өөрөөр хэлбэл нийт хуримтлал, цэвэр экспорт улс орны эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлж чадахгүй, бид үйлдвэрлэж байгаагийн хэмжээгээр хэрэглэж байна гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Иймд улс орны хөгжлийг эрчимжүүлэхэд хөрөнгө бүтээх тогтолцоог оновчтой бүрдүүлж, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зөв удирдахад онцгой анхаарал тавих нь чухал болж байна. Эс тэгвээс баялаг бүтээх хөрөнгийн үр ашиг буурч эдийн засгийн өсөлт удааширч нийгмийн хөгжил зогсонги байдалд орох болно.

Эцэст нь дүгнэж хэлэхэд Монгол Улсад хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны удирдлагын тогтолцоо нэг мөр болоогүйгээс хууль эрх зүйн баримт бичигт хөрөнгө оруулалтыг тодорхойлолтыг өөр өөрөөр томъёолж, зөвхөн хөрөнгө оруулагч субъектын эрх ашгийн өнцгөөс харж байгаа нь шинжлэх ухааны үндэслэл муутайгаас гадна улсын төсвийн хуулиар төсвийн хөрөнгө оруулалтын технологийн бүтцийг зөвхөн барилга байгууламж, тоног төхөөрөмж, их засвар гэсэн ангиллаар батлаж, статистикийн мэдээлэлд тусаж ирсэн нь улс орны хөгжлийн хүч хэрэгсэл болсон хөрөнгийн тухай, хөрөнгө оруулалтын утга ач холбогдол ойлголтыг нийгэмд нэг мөр болгох шаардлагыг бий болгож байна.

Нөгөө талаас эрдэмтэн, судлаачдын байр суурийг авч үзэхэд хамгийн ерөнхий утгаараа хөрөнгө оруулалт гэдэг нь ирээдүйд ямар нэгэн ашиг олох зорилгоор өнөөдөр гаргаж буй хөрөнгийн бууралт гэсэн үг болж байна.

Иймд бидний ойлголтоор “хөрөнгө оруулалт” гэж гадаад, дотоодын хуулийн этгээд, субъектээс шаардлагатай нөөц, хэрэгслийг ашиглан макро болон микро түвшинд ашиг олох, эерэг үр дүнд хүрэх зорилгоор нийгмийн хөгжлийн хэрэгцээг хангах, биет болон биет бус, оюуны баялаг бүтээхэд чиглэгдсэн өмч, хүч хэрэгслийг хууль, норм, стандартын хүрээнд бүтээн бий болгох, өргөтгөн шинэчлэх, дэмжих цогц үйл ажиллагаа юм”. Түүнчлэн хөрөнгө оруулалт гэдэг нэршлийг тодорхой зорилготой цогц үйл ажиллагаа гэдэг утгаар нь “Хөрөнгө бүтээх” гэсэн ухагдахуунд багтаах нь зүйтэй гэсэн санал дэвшүүлж байна.

Өөрийн өвөрмөгц онцлогтоо тохирсон шинжлэх ухааны тооцоотой хөгжлийн стратеги, урт, дунд хугацааны төлөвлөлтийн механизм байхгүй, төрийн бодлогын хэрэгжилт, залгамж чанар хангагдаагүй, аж үйлдвэр болон дэд бүтэц хөгжөөгүй, гадаад зах зээлээс өндөр хамааралтай уул уурхай, байгалын эрсдэлээс хараат мал аж ахуйн салбарт тулгуурласан, үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнээ бүгдийг нь хэрэглэдэг, импортоор өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнийхээ дийлэнхийг нь авдаг зэргээс шалтгаалан Монгол Улсын эдийн засагт хуримтлалын гүйцэтгэх үүрэг бараг байхгүйтэй адил байна.

Ашигласан ном зүй:

1. Адам Смит “Үндэстнүүдийн баялаг буюу түүний шалтгаан, гарал үүслийн тухай судалгаа” 2 дугаар дэвтэр 5 дугаар бүлэг 290 дахь тал Ч.Энхээгийн орчуулга Улаанбаатар хот 2011 он.
2. Альфред Маршалл “Эдийн засгийн ухааны зарчмууд” 109-113-р тал Чойбалсан хот 1997 он.
3. Карл Маркс “Капитал” том первый стр 210-222, Москва 1988 г.
4. Жон Мэйнард Кэйнс “Хөдөлмөр эрхлэлт, хүү зээл, хөрөнгө мөнгөний ерөнхий онол” 88-89-р тал, Улаанбаатар 2014 он.
5. Райзберг Б. А., Лозовский Л. Ш., Стародубцева Е. Б. Современный экономический словарь, М.:Инфра-М, 2006.
6. Ц.Аюурзана. “Санхүүгийн менежмент” УБ 2007 127-р тал
7. Д.Цэрэнпил “Санхүүгийн шинэчлэл: Судалгаа, тулгамдсан асуудал” УБ 2006 245-р тал.
8. Д.Моломжамц. “Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн шинэчлэлт” нэг сэдэвт бүтээл
9. <http://www.grandars.ru/student/ekonomicheskaya-teoriya/keyns.html>
10. <https://utmagazine.ru/posts/12838-norma-nakopleniya>